

ИХ Намын Улс Төрийн Зөвлөлийн
2016 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн
хурлаар батлав



ИРГЭНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ НАМЫН УИХ-ЫН 2016 ОНЫ СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Төрийн үйл ажиллагааг үнэлэх нь:

Иргэдийн оролцоогүйгээс хөгжлийн төлөвлөлт бодитой биш, улсын төсөв үндэслэл муутай, зарцуулалт нь хяналтгүй явсаар авлига, тэгш бус байдал, ядуурал газар авч, хүний эдийн засаг, нийгэм, соёлын эрхүүд бүрэн хэрэгжихгүйгээр 25 жил өнгөрлөө.

Улсын их хуралд суудалтай намууд, тэдгээрээс байгуулсан Засгийн газруудын хариуцлагагүй хандлага эх орныг маань үлэмж хэмжээний өрөнд унагааж, дамуурлын эрмэг дээр авчирч, Монгол Улсын баялаг, ард түмний хувь заяа, тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг өрийн барьцаанд орууллаа.

Ард түмнийхээ итгэлийг даахаа больсон засаг барьц алдаж, хүний улс төр, иргэний эрх, эрх чөлөөнд халдах зам руу гулсан орж байна.

2016-2020 онд зонхилох эдийн засаг, санхүүгийн нөхцөл байдал: Улсын маань эдийн засгийн өсөлт 2015 онд 2,3% хүртэл буурч, 2016 онд 0,1%, 2017 онд 0,5% болох төлөвтэй байна.¹ 2016 онд нийт гадаад өр дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ээс хоёр дахин, гадаад валютын нөөцөөс хорь дахин давж, 22 тэрбум ам. долларт хүрэв. Гадаад валютын нөөц 4 тэрбум ам. доллар байснаа 1,3 тэрбум болж, гадны юмаар амьдардаг бидний импортын хэрэгцээг хангахаа болив.² Улсын төсвөөс эргэн төлөгдөх өрийн нийт хэмжээг 4 жилд ДНБ-ний 62-54 хувьтай тэнцэнэ.³ 2016 оны өрийн төлбөрт 500 сая ам. доллар өгнө. Энэ нь иргэдийн маань нийгмийн хамгаалалд зарцуулах мөнгөнөөс⁴ хоёр дахиншүү юм. 2017 онд Засгийн газрын өрийн төлбөр 2,2 их наяд төгрөг болох тооцоотой. Хувийн хэвшлийн өр төлбөрийг нэмвэл 6,4 их наяд төгрөгийн эх үүсвэр хэрэгтэй болно.⁵ Гэтэл 2017 оны төсвийн зарлага хашаа ч хүрэхгүй 7,9 их наяд төгрөгөөр төсөөлөгдөж байна. Сангийн яам 2017-2018 оны төсвийн төсөөлөлдөө эдийн засгийн өсөлтийг 6,8%-иар, төсвийн зарлагыг 7,9 их наяд төгрөгөөр харж байгаа боловч ойрын төлөв туйлын эгзэгтэй байна.

АЛСЫН ХАРАА

Ард түмэндээ үнэнч асралт төртэй,
Эрүүл энх, эрдэм номтой, эд хөрөнгөтэй, эрх үүрэгтэй иргэдтэй,
Эх дэлхийгээ өн эртний ёсоор энхрийлэн хайрладаг хүн ардтай,
Орчлонг цогцоор нь ухаарч мэдэрдэг бодь сэтгэлтэй,
Хамтын оршихуй, нийтийн тусыг эрхэмлэсэн эвсэг, бат бэх улс үндэстэн болно.

¹ Азийн эдийн засгийн төлөв 2016, Азийн хөгжлийн банк.

² Монгол Улсын эдийн засаг, санхүүгийн салбарын тойм, Сангийн яам, 2015 оны 5-р улирал

³ “Монгол Улсын өрийн тогтвортой байдлын үнэлгээ”, Олон улсын валютын сан, 2015 он.

⁴ Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль

⁵ www.parliament.mn/files/download/110723

МОНГОЛ УЛС
ҮНДЭСНИЙ АУДИТ

УХА0122

№ 81
2016 он 04 сар

Сайн засаглалтай, төрийн зохицуулалт бүхий нийгмийн баримжаатай зах зээлийн эдийн засагт түшиглэсэн, хувийн болон нийтлэг эрх ашгийг зохистойгоор хангасан, хүний эрх, эрх чөлөөг баталгаатай эдлүүлсэн хүмүүнлэг, иргэний ардчилсаннийгэм байгуулахыг зорино.

ҮНДСЭН ЗАРЧИМ

ТӨРИЙН ОРШИН ТОГТНОХ ҮНДЭС СУУРЬ ИРГЭДЭЭС ҮҮСВЭРГЭЙ БӨГӨӨД ТӨРИЙН ЭРХ МЭДЛИЙН ЭХ СУРВАЛЖ ГАГЦХҮҮ ИРГЭДИЙН ХҮСЭЛ ЗОРИГ МӨН. ЭНЭХҮҮ ҮЗЭЛ САНАА БИДНИЙ ИХ НАМЫН ИТГЭЛ ҮНЭМШИЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТОДОРХОЙЛНО.

Төрт ёс: Төрийн бодлогын залгамж чанарыг эрхэмлэн төрийн үйл ажиллагааг гагцхүү үндэсний эрх ашигт захируулж нам, бүлэг, хувийн ашиг сонирхолоос ангил байгана.

Төр оршихийн утга учир, үндсэн зорилго ард түмнийхээ сайн сайхан амьдралыг хангах явдал гэж үзэж, төрийн дотоод, гадаад бүхий л бодлогыг энэ зорилгод зангидан явуулна. Төрийн үйл ажиллагааг гагцхүү ард түмний аж байдалд гарч буй эерэг өөрчлөлтөөр үнэлнэ.

Төр нь ард түмнээс олгосон бүрэн эрхээ хэрэгжүүлж, эх орны байгалийн баялгийг ард түмний ашиг тусын тулд эзэн ёсоор захиран зарцуулна.

Улсаа эдийн засаг, өрийн хямралаас гаргаж, хөгжлийн зөв гольдролд оруулахад чадварлаг Засгийн Газар онцгой үүрэгтэй гэж үзэж, түүнийг намын харьяалал, нас, хүйс харгалзахгүйгээр эрхлэх ажлын талаар мэдлэг мэргэшилтэй, батлагдсан туршлагатай ёс суртахуунч хүмүүсээс бүрдүүлнэ.

Улсын Их Хурлаас Засгийн газрын ажилд хутгалдан оролцохыг эцэс болгож, гүйцэтгэх засаглалын үйл ажиллагаанд хяналт тавих үүргийг нь эрс өндөржүүлж, байвал зохих түвшинд хүргэнэ.

Хуульг ёс: Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийг ямагт эрхэмлэн дээдэлж, хэлбэрэлтгүй сахина. Хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах, өөрийн үйл ажиллагаанд чанд биелүүлэх Үндсэн хуулиар заасан Засгийн газрын чиг үүргийг жинхэнэ ёсоор хэрэгжүүлэх чадавхтай, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлнэ.

Төрийн албан тушаалтныг томилоход “бялуу хуваах” зарчмыг хатуу цээрлэнэ. Төрийн албан хаагчаас гагцхүү ард түмэндээ үнэнч байж, алхам тутамдаа хуулиа дээдэлж, хууль бус шийдвэр, үйл ажиллагааг үл тэвчихийг шаардана.

Шударга ёс: Хуулийн хамгаалалыг Монгол Улсын иргэн бүрт хүргэж, хууль хүн бүрт адил үйлчлэхийн төлөө тууштай ажиллана. Зөв хууль, түвшин түшмэл, шударга шүүгч, журамт цагдаа шударга ёсны баталгаа мөн гэж үзнэ.

Хүмүүнлэг ёс: Нийгмийн бүлэг, цөөнхийн эрх ашгийг тусгах, хүн бүрийн санаа бодлыг сонсож харгалзах нь хүмүүнлэг нийгмийн үндсэн шинж мөн гэж үзэж, өөрсдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах чадваргүй, нийгмийн эмзэг бүлэг, иргэдэд туслах шинэлэг, зохистой арга хэлбэрийг эрэлхийлэн нэвтрүүлнэ.

Хүний эрх, байгаль орчны хамгаалагчдын аюулгүй байдлыг бодлого, хуулиар баталгаажуулна.

Хариуцлагатай төр: Төрийн эрх мэдлийн хуваарь, УИХ-ын хяналтын чиг үүргийг сэргээн тогтоож, УИХ-ын гишүүн ЗГ-ын гишүүн байхыг хуулиар хориглоно.

Ажилдаа тэнцэхгүй, ёс зүй алдсан төрийн албан тушаалтантай хариуцлага тооцох тогтолцоог бэхжүүлж, сонгогч итгэл найдварыг хөсөрдүүлсэн сонгуультаныг эгүүлэн татах эрхийг хуульчилна.

Ардчилсан нийгэмдэх хүний эрхийн хэрэгжилтэд төр нь үүрэг хүлээгч, иргэн нь эрх агуулагч мөн болохыг харгалзан шийдвэр гаргах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавихад иргэдийн бодитой оролцоог хангана.

Цэвэр улс төр: Хээл хахууль, авлигын бүх хэлбэрийг эцэс болгохын тулд төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын албан тушаалын эрх мэдэл, сүр нөлөөг хувийн ашиг сонирхлыг хангах зорилгоор урвуулан ашиглахыг таслан зогсооно. Мөнгөний сонгуулийг халж иргэд улс төрийн сонголтоо мэдлэг, ухамсраараа хийдэг тогтолцоог бэхжүүлнэ.

Өргөн суурьтай хөгжил: Хөгжлийн хэрэгцээг байгаль орчныг хамгаалах шаардлагатай зөв уялдуулан өмчлөлийн бүх хэлбэрийг үндэсний ашиг сонирхолд захируулан хөгжүүлж, бүтээгч эдийн засгийг байгуулна. Аж ахуйтныг улстөрчийн эрхшээлээс чөлөөлнө.

Хүний хөгжил болон хүний аюулгүй байдлын үзэл баримтлалыг төрийн бодлогын үндэс болгож, ард түмний эрүүл мэнд, боловсрол, ажил орлого, амьдралын аюулгүй орчинг хангах нийгмийн хөгжлийн үндсэн зорилтуудыг эн тэргүүнд хэрэгжүүлнэ.

Боловсрол, шинжлэх ухаан, технологийг эдийн засаг, нийгмийн хөгжлийн хөтөч гэж үзнэ.

Улс, нийгэм, ард түмэн хөгжин дэвжихэд улсын хэвшил түлхүү үүрэгтэй болохыг нотолсон орнуудын туршлагыг өөрийн оронд хэрэгжүүлнэ.

Санхүүгийн хүнд хэцүү нөхцөлд хийх ажлуудыг оновчтойгоор эрэмбэлж, хөрөнгө оруулалтын үр ашгийг хангаж, өрийг зээлээр төлөхгүй байх зарчмыг дагаж мөрдөнө.

Иргэний нийгэм, иргэний нийгмийн байгууллагуудыг ардчилсан засаглалын баталгаа болон хөгжлийн чухал хүчин зүйл болгож хөгжүүлнэ.

Нэг. Засаглалын хүрээнд

1.1. Төрийн албаны хууль тогтоомж, удирдлагын бүтэц, зохион байгуулалтыг төрийн алба зөвхөн чадахуйн зарчмаар бүрдэж, үйл ажиллагаагаа үндэсний язгуур ашиг сонирхол, нийтлэг эрх ашиг, хууль дээдлэх ёсоор явуулах зорилгод нийцүүлэн сайжруулна.

1.2. Нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгжийн хуваарийг Монгол орны эрчимтэй хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн өөрчилж, бүсчилсэн хөгжлийн арга стратегийг хэрэгжүүлнэ.

1.3. Монгол Улсын төрийн байгуулалтыг бэхжүүлэх зорилгоор Үндсэн хууль болон холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгож, нийт иргэд, сонгогчдын нийтлэг эрх ашиг, хүний эрх, эрх чөлөөг хамгаалсан зохицуулалт хийнэ.

1.4. Хууль тогтоох, гүйцэтгэх болон шүүх засаглалын эрх мэдлийн хуваарьт гарсан гажуудлыг үгүй болгож хууль ёсыг чанд сахих, шударга ёсыг хэлбэрэлтгүй мөрдөх зарчмыг тууштай хэрэгжүүлэн эрх зүйт төрийг бүрдүүлэх эрхзүй, зохион байгуулалтын арга хэмжээ авна.

1.5. Төлөөллийн зарчмыг хэрэгжүүлэх, төрийн шийдвэрийн чанарыг хангах, хяналт, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх үүднээс парламент дахь сөрөг хүчний эрх үүргийг хуульчилна.

МОНГОЛ
ҮНДЭСНИЙ АУ
УХАА

№ 8
20.16.04.С

1.6. Ашиг сонирхлын зөрчлөөс сэрэмжилсэн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, төрийн албан тушаалаа урвуулан ашигласан этгээдүүдэд хуулийн хатуу хариуцлага хүлээлгэдэг эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

1.7. Төрийн үйлчилгээг шинэ арга барилд шилжүүлнэ. Төрийн өндөр алба тушаалтнуудыг хөрөнгө орлогын мэдүүлгийг бүх иргэдэд хянуулах тогтолцоог бий болгоно.

1.8. Төрийн өмчийн хорооны архивыг нийтэд ил тод болгоно. Төрийн өмчийн хувьчлал, шалгаруулалтуудыг хөөн хэлэлцэж, хариуцлага тооцно.

1.9. Иргэний нийгмийн талаарх хууль тогтоомжийг шинэчлэн батлуулж, иргэний нийгмийн хөгжил, идэвхтэй үйл ажиллагааг бодлогоор дэмжинэ.

1.10. Ард нийтийн санал асуулга, нийгмийн бүлгүүдийн санал бодлыг тандах тогтолцоог боловсронгуй болгож ашиглана.

1.11. Хэвлэл, мэдээллийн эрх чөлөөг жинхэнэ утгаар хэрэгжүүлж, мэдээлэл түгээх эрхийг хуульчилж, дөрөвдөх засаглалыг бодит хүчин зүйл болгон төлөвшүүлнэ.

Хоёр. Гадаад бодлого, Үндэсний аюулгүй байдлын хүрээнд

2.1. Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах болон гадаад бодлогын үзэл баримтлалыг боловсронгуй болгоно.

2.2. Хүн, мал, ургамлын эрүүл, аюулгүй байдлыг ханган хамгаалах био бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

2.3. Газар, бэлчээр, усны эзэмшил, өмчлөлийн асуудлыг үндэсний язгуур эрх ашиг, аюулгүй байдалтай нягт холбоотойгоор авч үзэж, хамгааллын хатуу бодлого явуулна. Нийтийн өмчийн харилцааг зөв зохистой зохицуулах хууль тогтоомжийг бий болгоно.

2.4. Цацраг идэвхит бодисын хаягдлыг өөрийн нутаг дэвсгэрээр дамжуулан тээвэрлэх, түр байршуулах, хадгалахыг хатуу хориглосон бодлого, эрхзүйн орчныг бий болгоно.

2.5. Хоёр хөрш, НҮБ болон олон талт харилцааны бусад бүтцүүдийн хүрээнд харилцан ашигтайгаар хамтран ажиллахыг Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын чухал баталгаа гэж үзэн гадаад бодлогын тэргүүлэх чиглэл болгоно.

2.6. Дэлхийн улс оронтой тогтоосон уламжлалт найрсаг харилцааг үндэсний эрх ашигт нийцүүлэн хөгжүүлнэ.

2.7. Улсын хил хамгаалалтыг чанарын өндөр түвшинд гаргана.

Гурав. Эдийн засгийн хүрээнд

3.1. Монгол Улсын эдийн засаг нөхөн сэргээгдэх баялаг дээр суурилсан, хөрөнгө оруулалтын дотоод эх үүсвэрт тулгуурласан, бүс нутгийн интеграцид эрх тэгш түншлэгч байх ёстой гэж үзэж, эдийн засгийн хөгжлийн стратегийг боловсруулна.

3.2. Монгол Улсын эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг мал аж ахуй, газар тариалан, боловсрол, эрүүл мэнд, аялал жуулчлал, банк санхүү үйлчилгээний салбарт чиглүүлэн холбогдох дэд бүтцийг төсвийн хөрөнгө оруулалт болон хандивлагчдын зээл тусламжаар тэргүүн ээлжинд санхүүжүүлнэ.

3.4. Бүс, орон нутагт жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийг хөгжүүлэх зорилгоор ээлтэй татварын эрх зүйн орчинг бий болгож, аялал жуулчлал, боловсрол, эрүүл мэнд, банк санхүү болон үйлчилгээний салбарыг бүх талаар хөхиүлэн дэмжих цогц бодлого авч хэрэгжүүлнэ.

3.5. Монгол Улсын эдийн засгийн тэргүүлэх чиглэлд өндөр техник, технологинэвтрүүлж буй хувь хүн, аж ахуйн нэгж, албан байгууллагыг төрөөс хөхиүлэн дэмжинэ. Монгол Улс дэлхийн зах зээлд экологийн цэвэр хүнс нийлүүлэгч болох зорилт тавин ажиллана.

- 3.6. Татварын бодлогыг Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн хөшүүрэг болгох чиглэлийг баримтлан эрх зүйн орчинг өөрчилнө.
- 3.7. Хувийн хэвшлийг төрийн зохицуулалтын хэт дарамтаас чөлөөлөх чиг баримтална.
- 3.8. Стратегийн ач холбогдолтой эдийн засгийн салбаруудыг төрийн мэдэлд байлгана.
- 3.10. Жижиг дунд үйлдвэр, аж ахуйн нэгжийг тусгай бодлогоор хөхиүлэн дэмжинэ. Экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, экспорт орлох үйлдвэрлэлийг эхний ээлжинд төрийн бодлогоор дэмжих таатай орчин бүрдүүлнэ.

Дөрөв. Нийгмийн хүрээнд


- 4.1. Төрөөс Монгол хүн амын өсөлтөд онцгой анхаарал хандуулж тусгай бодлого гарган хэрэгжүүлнэ.
- 4.2. Улс орон, ард түмнийхээ төлөө өөрсдийн оюун санаа, хүч хөдөлмөрийг зориулсан ахмадуудаа дээдлэн хүндлэж, халамжлахыг төр ба иргэдийн эрхэм үүрэг болгоно.
- 4.3. Залуучуудын гэр бүл болох, орон сууц худалдан авах, бизнес эрхлэх, сурч боловсроход нийгмийн бодлогыг чиглүүлж ажиллана.
- 4.4. Хил хязгаар нутагт алба хааж буй болон амьдран сууж буй иргэдийн нийгмийн асуудлыг төрийн онцгой анхааралд авч цогц бодлого хэрэгжүүлнэ.
- 4.5. Улсын эмнэлгийг бэхжүүлэх, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд шударга өрсөлдөөний үндсэн хөгжих, эрүүл мэндийн үйлчилгээний чанарын стандартыг өндөржүүлэх, үйлчилгээний хүртээмжинд байгаа хот хөдөөгийн ялгааг арилгах бодлого хэрэгжүүлнэ.
- 4.6. Эрүүл мэндийн болон нийгмийн даатгалыг хувь хүнээс сонголттойгоор төлөх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
- 4.6. Төрийн эрүүгийн ялын бодлогыг эрс өөрчлөж хүний эрхийг дээдэлсэн, хүмүүнлэг, энэрэнгүй болгоно.

Тав. Боловсрол, соёл, шинжлэх ухааны хүрээнд

- 5.1. Сургуулийн өмнөх болон дунд боловсролын сургалтын хөтөлбөр, аргачлалыг үндэсний түүх уламжлалаа ухаарсан, орчин үеийн мэдлэгтэй, дэлхийн мэдрэмжтэй, бүтээлч сэтгэлгээтэй нийгэмшсэн хүнийг төлөвшүүлэх агуулга, арга хэлбэрээр баяжуулна.
- 5.2. Сургуулийн орчинг ялварлан гадуурхалт, хүчирхийллийн аливаа хэлбэрээс ангижруулж, хүмүүнлэг болгох тууштай арга хэмжээ авна.
- 5.3. Улсын их, дээд сургууль дундаж ангийн уурхай болж ирсэн хөгжингүй орнуудын туршлагыг санаж, дээд боловсролыг чанаржуулах арга хэмжээ авна.
- 5.4. Мэргэжлийн боловсрол сургалтын тогтолцоог түлхүү анхаарч, өргөжүүлэх бодлого явуулна.
- 5.5. Багшийн мэргэжил, мэргэшил дээшлүүлэх тогтолцоог сайжруулж багшийн хөдөлмөрийн нийгмийн үнэлэмжийг дээшлүүлнэ.
- 5.6. Соёл урлагын байгууллагуудын санхүүжилтийг нэмэгдүүлэх, оршин тогтнох нөхцлийг хангах шинэ арга хэлбэрийг эрэлхийлэн нэвтрүүлнэ.
- 5.7. Шинжлэх ухааныг хөгжлийн хөтөч хэмээн үзэж, оюуны амжилт, нээлт бүрийг эн тэргүүнд хөхиүлэн дэмжинэ.

Зургаа. Байгаль орчны хүрээнд

- 6.1. Монгол Улсын нутаг дэвсгэр дэлхийн шим мандлын олон улсын тусгай бүс байх чиг бодлогыг баримтлан олон улсын дэмжлэг авах чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулна.



6.2. Монгол орны онгон байгалийг хамгаалах, зүй зохистой ашиглах, үүнд хувь хүн, нутгийн хамт олныг идэвхтэй оролцуулах хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгоно. Байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх бүх үйлдлийг ~~таслан~~ зогсооно.

6.3. Хүний зохисгүй харьцаанаас болж байгальд учруулсан хор хохирлыг багасгах, байгальд нөхөн сэргээлт хийх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр үр дүнтэй зохион байгуулна.

6.4. Монгол оронд нүүрлээд байгаа цөлжилтийг зогсоох талаар эрдэм шинжилгээний болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллана.

*Хариуцлагын хувьсгал хийж,
Хөдөлмөрийг алдаршуулж,
Эх орноо зүрхнээсээ хайрлана!*

27
Өдөр

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30

2016.04.27 № 815

танай _____-ны № _____-т

Нийцлийн талаарх дүгнэлт

Монгол Улсын Их Хурлын 2016 оны ээлжит сонгуульд оролцохоор бүртгүүлэх хүсэлт гаргаж байгаа Иргэний хөдөлгөөний намын “Сонгуулийн мөрийн хөтөлбөр”-т Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хянаж дүгнэлт гаргав.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Улсын Их Хурлын ээлжит сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Сонгуулийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж, хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний санхүүгийн эх үүсвэрийн талаарх тооцоо, судалгааг Төрийн аудитын байгууллагад ирүүлж Сонгуулийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5-д заасны дагуу дүгнэлт гаргуулах хариуцлага хүлээнэ.

Үндэсний аудитын газар Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.17-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд намын боловсруулсан сонгуулийн мөрийн хөтөлбөр Сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуультай нийцэж буй эсэх талаарх дүгнэлтийг Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5-д заасан хугацаанд Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлэх үүрэгтэй.

Дүгнэлтийн үндэслэл

Үндэсний аудитын газар УИХ-ын ээлжит сонгуульд оролцох Иргэний хөдөлгөөний намаас ирүүлсэн “Сонгуулийн мөрийн хөтөлбөр”-ийг Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт-4000, Төрийн хяналт шалгалтын стандартыг удирдлага болгон Сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль болон “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2018 оны төсвийн төсөөллийн тухай хуульд нийцүүлэн дүгнэлт гаргав.

Дүгнэлт

Иргэний хөдөлгөөний намын Сонгуулийн мөрийн хөтөлбөр нь Сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2018 оны төсвийн төсөөллийн тухай хуультай нийцсэн болно.

Хувийг: Иргэний хөдөлгөөний намд

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД

000017